

71



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 08 сарын 21 өдөр

Дугаар 78

Номгон

Ашигт малтмалын хайгуулын тусгай
зөвшөөрөл олгохгүй байх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн “Талбайн солбицлыг тогтоох тухай” 243 дугаар тогтоолын хавсралтаар баталсан сонгон шалгаруулах журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайгаас 65,449.49 га талбайг хасах саналыг дэмжсүгэй.

2. Уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтын журмаар олгох талбайд нэмэх саналд дурдсан 722,616.93 га талбай нь малчин иргэдийн өвөлжөө, хаваржааны бүс нутаг тул нэмэх саналаас татгалзсугай.

3. Дээрх саналыг хуулийн хугацаанд Ашигт малтмал, газрын тосны газарт уламжлахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

